

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМД**

Давж заалдах журмаар гомдол гаргах нь:

Давж заалдах журмаар гомдол гаргагч- Нэхэмжлэгч: Таван Богд Холдингс ХХК

Нэхэмжлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-6
Хаан цамхаг 10 давхарт

Нэхэмжлэгчийн

итгэмжлэгчдээн төлөөлөгч: Т.Солонго /99901521/

Хариуцагч: Монголбанк /Монгол Улсын Төв банк/

Хариуцагчийн хаяг: Улаанбаатар хот, Багатойруу-3

Утас: 310081, 310392, 320380, 322847

Гомдлын үндэслэл:

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022.5.5 № А-1/476 тоот захиргааны актыг хүчингүй болгуулах болон Эй Эс Холдингс ХК-ийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулсан тухай бүртгэлийг хүчингүй болгох тухай нэхэмжлэлийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэн 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 221/ШШ2024/0039 тоот шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Иймд Захиргааны хэрээ шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дугаар зүйлийн 114.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэрийг бүхэлд нь хулээн зөвшөөрхгүй байх тул давж заалдах журмаар гомдол гаргаж байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэх гаргасан шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангагүй бөгөөд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн нь шүүхийн шийдвэр гараадад нөлөөлсөн гэх нэхцэл байдал бүрдсэн гэж үзэж байна.

Нэг. Шүүх хэрэглэх ёстой хуулийн заалтыг хэрэглээгүй, Захиргааны Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1-т заасны дагуу нотлох баримтыг тал бүрзэс нь бодитойгоор харьцуулан үнэлээгүй тухай:

Шийдвэрийн ҮНДЭСЛЭХ хэсгийн 3 дах заалт, шийдвэрийн ТОГТООХ хэсэгт Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.11 дэх заалтыг иш татан тусгаж, дараах дүгнэлтийг гаргаж буй боловч здгээр зүйл заалтуудыг тайлбарлан хэрэглээгүй, ач холбогдол бүхий нотлох баримтыг дүгнээгүй байна.

2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 221/ШШ2024/0039 тоот шийдвэрийн ҮНДЭСЛЭХ нь хэсгийн 3.3 дахь хэсэгт "Энэ нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6... , Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А/82 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Банкны Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журамын 4.1-д гэж тус тус заасантай нийцэж байх тул хариуцагч Монголбанкыг дээрх хууль журамд заасны дагуу хянан үзэж шийдвэр гаргасан гэж үзэхээр байна" гэж үндэслэлгүй дүгнэлтийг хийсэн.

Энэхүү Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг хууль зөрчсөн болохыг тайлбарлавал

ХААН Банкны 60 хувийн хувьцааг эзэмшигч Япон Улсын Савада Холдингс компанийн эцсийн өмчлөгчийг өөрчлөх хэмжээний тендерийг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Япон Улсын Мета Капитал компанийн хөрөнгө оруулалттай Уpsilon Инвестмент хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл ("Уpsilon") зарласан байдал.

Тендер зарлаж банкны хувьцаа эзэмшигч өөрчлөгдхөг гэж байгааг Монголбанк олж мэдээд, ХААН Банк ХХК-иар дамжуулан урьдчилан зөвшөөрөл авах байр сууриа илэрхийлж, албан бичиг хүргүүлж байсан.

Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй, Монголбанкны зохих зөвшөөрлийг урьдчилсан байдлаар аваагүй, худалдан авагч талын эцсийн өмчлөгчийн хөрөнгийн гаралт үүсэл, орлогын эх үүсвэрэйг хөндлөнгийн хараат бус байгууллагаар тодорхойлж, хангалттай нотлох баримтыг бүрэн бурддүүлээгүй тус тендер нь 2021 оны 7 дугаар сарын 16-ны өдөр амжилтгүй болж, дуусгавар болсон байдал.

Энэ талаар мэдээллийг ХААН Банкны 2021 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 11/6191 тоот албан бичгээр Монголбанкинд мэдэгдсэн юм. Тендер дууссаныг мэдэгдсээр байтал Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн нь 2021 оны 7 сарын 26-ны өдөр А-1/761 тоот албан бичгээр Япон Улсын Мета Капитал компанийн хөрөнгө оруулалттай Уpsilon-нд дуусгавар болсон тендерийн хүрээнд хууль бусаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах талаар зөвшөөрөл олгосон. Гэтэл энэхүү зөвшөөрлийг зөвшөөрөл олгосонд тооцон Япон Улсын Савада Холдингс нь компанийн эцсийн өмчлөгчийг өөрчлөх хэмжээний хэлцлийг хаалттай байдлаар хийсэн байдал. Энэ нь зохих журмын дагуу зөвшөөрөл аваагүйг илтгэж байна.

Мөн түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А/82 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Банкны Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмын 4.1-д Банк нь буюу Хaan банкнаас хүсэлтийг Монголбанкад хүргүүлэх тухай зохицуулсан байдал. Мөн түүнчлэн тус журмын 5 дугаар зүйлийн 5.6-д "Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох боломжтой гэж үзсэн тохиолдолд Монголбанкны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн газар, хууль эрх зүйн асуудал эрхэлсэн газар, телбер тооцоо буртгэлийн асуудал эрхэлсэн газар, мэдээлэл технологийн асуудал эрхэлсэн газар санал дүгнэлтээ Ерөнхийлөгчид танилцуулж шаардлагатай тохиолдолд Монголбанкны хяналт шалгалтын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасан байдал.

Гэтэл Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А-1/476 дугаар албан бичгээр дээрх зохицуулалтыг зөрчин холбогдох газруудаас дүгнэлтийг авалгүй бие даан зөвшөөрөл олгосон байдал.

Энэ талаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Т.Энхмаа шүүгч зөв дүгнэлтийг хийж журмын 5 дугаар зүйлийн 5.6-д заасан зохицуулалтын дагуу гаргасан холбогдох шийдвэрүүдийг авахаар 2023 оны 10 дугаар сарын 12-нд 2/2289 тоот албан бичгээр нотлох баримт авахаар даалгасан байдал боловч Монголбанкнаас 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 6-10/897 тоот албан бичгээр журмыг илтэд гүйвуулан тайлбарлаж шүүхээс шаардсан нотлох баримтыг гаргаагүй болохоо дурдсан.

Мөн түүнчлэн тухайн шүүхийн шийдвэрт ишилж буй Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А/82 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Банкны Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журмын 4.1-д Банк өөрийн нэрийн өмнөөс хүсэлтийг гаргахаар зохицуулсан.

Гэтэл шүүхийн шийдвэрт Банк хүсэлт гаргах тухайд дүгнэлт хийлгүй харин шийдвэрийн 3.5-д Энэ талаарх хариуцагчийн итгэмжлэгдсан төлөлөгч нарын "...Хaan Банк ХХК-иас зөвшөөрөл хүсэж ирүүлсэн холбогдох баримтыг шалгахад Банкны тухай хуульд

заасны дагуу зөвшөөрөл олгохоос татгалзах үндэслэлгүй байсан тулгэх тайлбарыг хүлээн авах үндэслэлтэй байна гэж дүгнэсэн нь хууль зүйн үндэслэлгүй юм.

Учир нь ХААН Банкийг төлөөлж Монголбанкинд хүсэлт гаргах эрх бүхий этгээд нь гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа бөгөөд тэрээр Эйч Эс холдингс ХК-ийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулах талаар хүсэлтийг албан ёсоор Монголбанкинд хандаж гаргаагүй болно. Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.8¹-д компанийг төлөөлөх эрх бүхий этгээд нь Гүйцэтгэх удирдлага байхаар зохицуулсан.

Мөн түүнчлэн ХААН Банк ХХК-ийн ТҮЗ-өөс 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр болон 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрүүдэд тус тус хэлэлцэж Савада Холдингс компанийн хувьцааг худалдан авагч хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний мөнгөний гаралт үүслийг эцэслэн тодорхойлж нотлоогүй байхад тус компанийн хувьцаа эзэмшилийн бүтцэд өөрчлөлт оруулах хэлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй, зөвшөөрөл хүссэн хүсэлтийг ХААН Банкаар дамжуулан Монголбанкинд гаргах боломжгүй талаар шийдвэрлэсэн бөгөөд уг тогтоолыг Монголбанкинд хүргүүлсэн юм.

Харин ТҮЗ-ийн нарийн бичгийн даргаас мэдээлэл дамжуулах зорилгоор хувьцаа эзэмшигч Эйч Эс холдингс ХК-ийн ируулсан баримт мэдээллийг орчуулж Монголбанкинд хүргүүлж байсан бөгөөд үүнийг 2022 оны 5 сарын 5-ны өдрийг хүртэл Монголбанк ч, ХААН Банк ч зөвшөөрөл хүсэж хандаж байна хэмээн ойлгож хүлээж авч байгаагүй болно. Тодруулбал:

ХААН Банкны ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ариунтулгаас 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдөр 11/1979 тоот албан бичгээр "Мэдээлэл дамжуулах тухай" хэмээн хаяглаж Монголбанкинд хандсан бөгөөд "...банкны нэлэө бүхий хувьцаа эзэмшигч Эйч Эс Холдингс" компанийн хувьцаа эзэмшилийн бүтцийн өөрчлөлтийг Монголбанкны зүгээс зохих зөвшөөрөл олгосон эсэх нь тодорхойгүй байгаа тул зохих ёсоор тайлагнахад хүндрэл учруулж байна. ...Эйч Эс Холдингс компанийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд тайлагнаж чадахгүй байгаа болохыг мэдэгдэж байна" гэжээ.

Уг албан бичгийн хариуд Монголбанкны өрөнхийлгэч Б.Лхагвасурэн 2022 оны 3 сарын 28-ны өдөр А-1/308 тоот албан бичгээр ХААН Банкны гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяад хаяглаж хариу ирүүлэхдээ: "Танай банкны нэлэө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулах тухай эцсийн зөвшөөрлийг хуулийн хүрээнд Монголбанкнаас олгож бүртгэл хийгдээгүй байна. Танай банк хуулиар хүлээсэн үүргийн дагуу ...банкны нэлэө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулах тухай зөвшөөрлийн хүснэгтээ Монголбанкинд албан бичгээр ирүүлсний дараа холбогдох хүсэлтийг судлаж, хариу хүргүүлэх хуулийн зохицуулалттай байна" гэжээ.

ХААН Банкны ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ариунтулгаас 2022 оны 4 сарын 4-ний өдөр дахин 11/2178 тоот албан бичгээр "Мэдээлэл дамжуулах тухай" хэмээн хаяглаж Монголбанкинд хандсан бөгөөд "ХААН Банкны нэлэө бүхий хувьцаа эзэмшигч Эйч Эс Холдингс ХК-ийн хувьцааг худалдан авсан Уpsilon Инвестмэнт ХХН-ийн өрөнхий партнэр Метакапитал компанийн зүгээс хавсралт дахь албан бичиг ирснийг орчуулан хүргүүлж байна." гэжээ.

Уг албан бичгийн хариуд Монголбанкны Хууль эрх зүйн газрын захирал Д.Аюуш 2022 оны 4 сарын 8-ны өдөр А-10/362 тоот албан бичиг ирүүлсэн бөгөөд уг бичигт "ХААН Банкны нэлэө бүхий хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ бүтцэд өөрчлөлт оруулах тухай зөвшөөрелтэй холбоотойгоор холбогдох этгээдээс гаргасан хүсэлтийг танайхаас Монголбанкинд дамжуулах бус дээрх

¹ 83.8.Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэрэгээр компанийн нарийн өмнөөс ИПЭМЖЛЭЛДҮҮГЭЭД уйл ажиллагаа явуулна.

ХУСЭЛТТЭЙ ХОЛБООТОЙГООР ТАНАЙ БАНК ӨӨРИЙН НЭРИЙН ӨМНӨЕС МОНГОЛБАНКИНД ЗЕВШӨӨРӨЛ ХУСЭЖ ИРҮҮЛЭХ ХУУЛИЙН НИЙЦЛИЙГ ХАНГАНУУ" ГЭЖЭЭ.

Энэхүү Монголбанкны хууль эрх зүйн газрын захиралын албан бичгийн хүрээнд 022 оны 4 сарын 14-ний өдөр ХААН Банкны гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа 01/2427 тоот албан бичгээр Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнд хандаж: ...Эйч Эс Холдингс ХК-ийн хувьцаа эзэмшилийн бүтцэд орсон өөрчлөлтийн дараагаар банк нь зевшөөрөл хүссэн албан ёсны хүсэлтийг Монголбанкинд албан бичгээр нөхөж гаргах эсхийг Банкны ТУЗ хэллэлцээд 2022 оны 4 сарын 12-ны өдрийн 14 тоот тогтооолор "нөхөж зевшөөрөл хүссэн хүсэлт гаргахгүй" байх талаар шийдвэрлэсэн болохыг дурьдаад, Монголбанкнаас нөхөж зевшөөрөл олгох талаар хүсэлт гаргах нь хууль зүйн боловижгүй талаар мэдэгдсэн байдаг. Гэвч уг албан бичгийн дараа 2022 оны 5 сарын 5-ны өдөр Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн А-1/476 тоот албан бичгээр Эй Эс Холдингс ХК-ийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулсан тухай бүртгэлийг хийсэн болно" гэжээ.

Уг албан бичиг нь нэгдгүээрт агуулгын хувьд зөрчилтэй болсон байна. Учир нь "Танай 2022 оны 4 сарын 4-ний өдрийн 11/2178 дугаар албан бичгээр ирүүлсэн Упсолин ХХН-ийн хүсэлттэй танилцлаа... гэж эхний хэсэгт дурьдсан атлаа албан бичгийн төгсгөлд "Банкнаас ирүүлсэн хүсэлтийн дагуу баримт бичгийг хянаж үзээд Эй Эс Холдингс ХК-ийн хувьцааны бүтцэд өөрчлөлт оруулсан тухай бүртгэлийг хийсэн болно" гэсэн нь мэдээлэл дамжуулах тухай бичгийг ХААН Банкны зевшөөрөл хүссэн хүсэлт мэтээр илт гүйвуулан тайлбарласан байна.

Хоёрдугаарт: ХААН Банкны ТУЗ дээрх агуулга бүхий зевшөөрлийн хүсэлт Монголбанкинд гаргахгүй байх талаар шийдвэрлэсэн бөгөөд банкийг төлөөлж Монголбанкинд зевшөөрөл хүсэж хандах эрх бүхий этгээд болох гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа хүсэлтээ хуульд заасан журмын дагуу гаргаагүй байхад Монголбанкны ерөнхийлөгч бүртгэл хийж энэ талаараа банкинд мэдэгдэж байгаа нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай зевшөөрлийн журмын 1.3.4-т заасан хууль, журмын зохицуулалтыг зөрчиж байна.

Гэтэл шүүхийн шийдвэрийн 4.1-д Монголбанкны Ерөнхийлөгчид хандан Хаан банк ХК-ийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Ариунтулга хүсэлт гаргасан гэж илтэд алдаатай дүгнэлтийг хийсэн. О.Ариунтулга нь ТУЗ-ын дарга бус нарийн бичгийн дарга юм.

Эдгээр нэхэмжлэгч талаас гаргасан Хаан банкыг төлөөлөх эрх бүхий этгээдээс Монголбанкны Ерөнхийлөгчид хандсан албан бичиг болон Монголбанкны хууль эрх зүйн газрын захирлаас хүртэл хуулийн нийцлийг хангахыг шаардсан баримтууд байсаар атал шүүх шийдвэр гаргахдаа үл хайхарч, шүүхийн шийдвэр үндэслэл бүхий, зргэлзээгүй байх зарчмыг зөрчиж шийдвэрлэсэнд гомдолтой байна.

Хоёр. Нэхэмжлэгчийн зүгээс эрх ашиг нь хөндөгдөж буй эсэх талаар нотлох баримт шаардсан дүгнэлтийн тухайд:

2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 221/ШШ2024/0039 тоот шийдвэрийн 3.6-д Өөрөөр хэлбэл, Хаан банкны нелөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг Монголбанк хүлээн авч шалгаад холбогдох тохиолдод Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А-1/476 тоот захиргааны актын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна. 3.7-д Нэхэмжлэгчээс "... маргаан бүхий актын улмаас.... бизнесийн хэвийн үйл ажиллагаанд сергээр нелөөлөх эрсдэл үүсэж банкны төлбөр гүйцэтгэх чадварт сергээр нелөөлж, банкны зохистой харьцааны түвшин алдагдах зэрэг Хаан Банкны хувьцаа эзэмшигч нарын эрх ашигийг шууд хөндөж байна" гэж тайлбарласан боловч энэ талаарх нотлох баримтыг гаргаж өгөгүйгээс гадна Хаан банкны зүгээс ч тэр эрх нь

Зөрчигдэж, уйл ажиллагаа доголдсон, ашиг орлого буурсан, нэр хүнд нь унасан талаар тайлбар, баримт ирүүлээгүй байх тул нэхэмжлэгчийн энэ талаарх тайлбар үндэслэлгүй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус уйл ажиллагааны улмаас зөрчигдсэн, эсхүл зөрчигдэж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харицааг зохицууладх оршино гэж заасан хүрээнд нэхэмжлэгч байгууллага "Таван Богд Холдингс" ХХК нь өөрийн зөрчигдэж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалулахаар шүүхэд хандсан.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.1.7-д "Нэхэмжлэл" гэж иргэн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус актын улмаас зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалулахаар захиргааны хэргийн шүүхэнд хандаж гаргасан өрөөдлийн хэлнэ. Шүүх нэхэмжлэлийг хүлээн авахдаа маргаж буй захиргааны акт нь нэхэмжлэгчийн эрхийг зөрчсөн болохыг тогтоож нотолсон байхыг шаардахгүй, маргаан бүхий захиргааны шийдвэр, уйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсэн байж болзошгүй нь, түүнчлэн зарим төрлийн нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдэж болзошгүй нь нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэлээр тодорхойлогдож байгаа тохиолдолд "нэхэмжлэл гаргах эрх бүхий этгээд" гэж үзнэ.²

Нэхэмжлэл дурдсаны дагуу "Таван Богд Трейд" ХХК нь Хаан Банк ХХК-ийн 43,565,310 ширхэг буюу 25.31 хувийн хувьцаа эзэмшдэг. Монголбанкны Ерөнхийлгэчийн 2022 оны 05 сарын 05-ны өдрийн А-1/476 тоот захиргааны актын улмаас Хувьцаа эзэмшигч "Таван Богд Трейд" ХХК-ийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдэж байгаа тухай дурдаж, бидэнд үүсэж буй эрсдэлүүдийг тодорхой тусгасан билээ.

Мөн манай компанийн зүгээс Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангах тухай №01A-296 дугаартай албан тоотыг 2022 оны 08 сарын 01-ний өдөр хүргүүлсэн билээ.

Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.Захиргааны хэргийн шүүх хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт цуглуулах, үнэлэх ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд хэргийн оролцогчийг татан оролцуулна гэж заасан байдаг ба шүүхийн зүгээс шууд нэхэмжлэгчийг нотлох баримт гаргаж өгөөгүй үндэслэлээр буруутган хэргийг хэрэгсэхгүй болгож буй нь нэхэмжлэгч талын эрх ашгийг зөрчиж байна.

Хаан банкны зүгээс шүүхийн шийдвэрийн 3.7-д заасны дагуу тайлар, нотлох баримт гаргах үүргийг хүлээгээгүй болон шүүхийн зүгээс Хаан банкнаас дээрх тайлбар авахаар хандаагүй байж шууд дүгнэн үнэлэх нь шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх зарчмыг зөрчиж байна.

Иймд 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 221/ШШ2024/0039 тоот шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж өгнө үү.

Хүндэтгэсэн,

ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ  Т.СОЛОНГО

² Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай, Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоол, УБ хот, 2023 оны 07 сарын 03 өдөр



УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН ТАНХИМД

ӨМГӨӨЛӨГЧ Л.НИНЖБАТ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
3-р хороо, Улаанбаатар-15172,
“PEACAS TOWER” оффисийн 1712 тоот
Утас: 9911-8570

Огноо 2024.12.16 № 0015

танаай _____ -ны № _____ -д

Давж заалдах гомдол гаргах тухай

Нийслэлийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх “Таван Богд Трейд” ХХК-ийн нэхэмжлэлтэй Монголбанкны Ерөнхийлөгчид холбогдох захиргааны актыг хүчингүй болгох захиргааны хэргийг 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөр анхан шатны журмаар хэлэлцээд 271/ШШ2024/0039 дугаартай шийдвэрээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэснийг дараах үндэслэлээр эс зөвшөөрөч давж заалдах гомдол гаргаж байна.

Нэг. Шүүхийн 0039 дугаартай шийдвэрийн ҮНДЭСЛЭХ нь хэсгийн 3.2-т “Хэрэгтэй авагдсан баримтуудаас үзэхэд, Хаан банк нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигч “Эйч Эс Холдинг” ХК-ийн хувьцааг нь худалдан авсан “Упсилон Инвестмент” ХХН-ийн ерөнхий партнер Мета Капитал компани нь хувьцааг худалдан авах тухай зөвшөөрөл хүсэж, бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлтийг Монголбанкны Ерөнхийлөгчид 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр гаргасан байх бөөөөд холбогдох хувь нийлүүлсэн хөрөнгийн гарал үүсэл, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлсон баримт, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг хавсаргажээ” гэжээ.

Улмаар 3.3-т “Энэ нь Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д ..., ... журмын 4.1-д ... гэж тус тус заасантай нийцэж байх тул Монголбанкны дээрх хууль, журамд заасны дэгүү хянан үзэж шийдвэр гаргасан гэж үзэхээр байна” гэжээ.

Түүнчлэн 4.1-д “Монголбанкны Ерөнхийлөгчид хандан “Хаан банк” ХК-ийг төлөөлж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга О.Ариунтулга хүсэлт гаргасан байх тул нэхэмжлэгчийн “Монгролбанкин” зөвшөөрөл хүсэж хандах эрх бүхий этгээд гүйцэтгэх захидал бөөөөд гүйцэтгэх захидал нь хүсэлтийг хууль, журмын дагуу Монголбанкин “гаргаагүй” гэх үндэслэлийг хүлээн авах боломжгүй төдийгүй уг үндэслэлээр шууд хариуцагчийг буруутгаж, маргаан бүхий актыг хүчингүй болгох үндэслэлгүй байна” гэжээ.

Нэхэмжлэгч шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ, мөн шүүх хуралдаанд “Хаан банк” ХК-ийн ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ариунтулгын Монголбанк руу явуулсан 2022 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн бичгийн талаар дэлгэрэнгүй тайлбар оруулсан боловч давж заалдах шатны шүүх ойлгоогүй юм уу, эсвэл ойлгосон ч үл тоосон уу, отт бодит байдзэлд нийцээгүй, зарим талаар хэт мэргэжлийн бус тайлбар, дүгнэлт хийсэн гэж үзэж байна.

- 1.1. Юуны түрүүнд ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ариунтулга Монголбанк руу явуулсан 2022 оны 04 дугээр сарын 04-ны өдөр явуулсан 2178 тоот албан бичгийнхээ агуулгыг "Мэдээлэл дамжуулах тухай" гэж тодорхойлсон нь бичгийн баруун дээд буланд бичигдсэн байгааг онцолж байна. Өөреөр хэлбэл "Хaan банк" ХК-ийн ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга хүсэлт илгээж байгаа бус, харин мэдээлэл дамжуулж байгаагаа илрэхийлжээ.
- 1.2. 2178 дугаартай бичгийн эхний өгүүлбэрт "ХААН банк ХХК-ийн нэлээ бүхий хувьцаа эзэмшигч Эйч Эс Холдинг ХК-ийн хувьцааг худалдан авсан Упсилон инвестмент ХХН-ийн ерөнхий партнэр Мета Капитал компанийн зүгээс хавсралт дахь албан бичиг ирснийг албан ёсны орчуулгын үүгээр хүргүүлж байна" гэсэн байдаг. Өөреөр хэлбэл, хувьцаа эзэмшигчээс ирсэн бичгийг орчуулж танайд хүргүүлж байна гэсэн утга агуулга байна.
- 1.3. 2178 дугаартай бичгийн хоёр дахь өгүүлбэрт "Тус компанийн зүгээс Монголбанкны "Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-д заасны дагуу шаардлагтай баримт бичгүүдийг бүрдүүлж, нэмэлтээр шаардсан бүх баримт бичгүүдийг гаргаж өгсөн тул Монголбанкаас холбогдох зөвшөөрлийг олгож өгөхийг хүссэн байна" гэсэн байдаг. Өөреөр хэлбэл, "тус компанийн" гэдэг нь Мета Капитал компанийн зүгээс зөвшөөрөлт олгох өгөхийг хүссэн тухай хүсэлтийг нь дамжуулж байгаа утга агуулга байна.
- 1.4. 2178 дугаартай бичгийн хамгийн доод хэсэгт "ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ариунтулга" гэсэн байдаг.

Гэтэл давж заалдаш шатны шуух "Монголбанкны Ерөнхийлөгчид хандан "Хaan банк" ХК-ийг төлөөлж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга О.Ариунтулга хүсэлт гаргасан" гэж албан тушаалыг тодорхойлсон нь илтэд ташаа байгааг Захиргааны хэргийн танхимаас анхаарахыг хүсэж байна. Учир нь, ТҮЗ-ын дарга болон ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга гэх хоёр албан тушаал нь Компанийн дүрэмд зааснаар огт өөр эрх хэмжээ, бүрэн эрхийг эдлэх субъектууд юм.

ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга О.Ариунтулга нь "Хaan банк" ХХК-ийг төлөөлж хэз нэгэнд хүсэлт гаргах эрхтэй албан тушаалтан биш болно.

"Хaan банк" ХХК-ийн дүрмийн 13.7.18-д "Гүйцэтгэх захирал ТҮЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, Банкийг төлөөлэх зэргээр Банкны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах, тодорхой асуудлаар Банкийг төлөөлэх итгэмжлэлийг бусдад олгох эрхтэй" гэсэн байна. Банкыг төлөөлөх онцгой эрх зөвхөн "Хaan банк" ХХК-ийн гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяад хадгалагджад байна.

Тийм ч учраас 2022 оны 04 дугээр сарын 08-ны өдөр Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш А-10/362 дугаартай албан бичигтээ "Иймд Хaan банк ХХК-ийн нэлээ бүхий хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай зөвшөөрлтэй холбоотойгоор холбогдох этгээдээс гаргасан хүсэлтийг танайхаас Монголбанкинд дамжуулах бус дээрх хүсэлтийг холбоотойгоор танай банк өөрийн нэрийн өмнөөс Монголбанканд зөвшөөрөлт хүсэж ирүүлэх хуулийн нийцлийг хангана уу" гэсэн мэдэгдлийг ирүүлж байжээ.

Үүний дараа "Хaan банк" ХХК-ийн гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа 2022 оны 04 дугээр сарын 14-ний өдөр 01/2427 дугаартай албан бичгээр Монголбанкинд хандаж "Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 дугээр сарын 12-ны өдрийн 14 тоот тогтооолоо "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хувьд Япон Улсын Упсилон

Инвестмент ХХН/Мета Капитал компанийтай холбоотой Эйч Эс Холдингс компанийн хувьцаа эзэмшилийн бүтцэд орсон өөрчлөлтийн дараагаар Банк нь зөвшөөрөл хүссэн албан ёсны хүсэлтийг Монголбанканд албан бичгээр нөхөж гаргахыг зөвшөөрөөгүй байх" шийдвэр гаргасан..." гэж мэдэгдсэн байна.

Дээрх үйл баримтуудыг нотолсон нотлох баримтууд бүгд хэрэгт авагдсан байхад давж заалдах шатны шүүх нотлох баримтыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1-т "Шүүх хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь бодитойгоор харьцуулан үзэсний үндсэн дээр өөрийн дотоод итгэлээр үнэлнэ" гэж, 34.2-т "Нотлох баримтыг тухайн хэрэгт хамаарлтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ" гэж заасныг хэрэгжүүлж нотлох баримтыг үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлж чадаагүйгээс бодит байдал болон хуульд нийцэгүй дүгнэлт хийсан болохыг анхаарахыг хүсэж байна.

Хоёр. Шүүхийн 0039 дугаартай шийдвэрийн ҮНДЭСЛЭХ нь хэсгийн 3.6-д "... Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А-1/476 тоот захиргааны актын улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна" гэжээ.

2.1 Монгол Улсын Банкны тухай хуулийн 19.1 дүгээр зүйлийн 19.1.4 дэх хэсэг, 20.1 дүгээр зүйлийн 20.1.7 дахь хэсэг, мөн хуулийн 36 дугаар зүйл, Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийг болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн А-82 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан ЗБанкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-ын 6.1 дүгээр зүйлд заасныг тус тус зөрчсөн гэх үзэж захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасныг зориуд тэмдэглэж байна.

Өмчлөл, засаглалын хувьд тогтвортгүй, хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн бүрдэл нь хууль ёсны байх шаардлагыг хангахгүй Банкны тухай хууль болон Монголбанкны журмыг зөрчиж, үл тоосон байдлаар үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдтэй Монголын нөлөө бүхий банкыг хамтран удирдана гэдэг бол "Таван Богд Трейд" ХХК-ийн хувьд бизнесийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх маш том эрсдэл гэж үзэж байгаа юм.

ХААН банк гадаадын банк болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас их хэмжээний урт хугацааны санхүүжилтэй бөгөөд банкны хувьцаа эзэмшигчийн бүтэц, хэмжээнд өөрчлөлт орсон даруйд тэдэнд мэдэгдэх үүрэгтэй байдаг. Гэтэл үүссэн зөрчилтэй нөхцөл байдлын улмаас дээрх олон улсын байгууллагуудад хэрхэн мэдээлэх эсэх нь ойлгомжгүй байна. ХААН банк, гадаадын банк болон олон улсын санхүүгийн байгууллагуудад бодит мэдээлэл өгөгүйгээс тухайн этгээдүүд ХААН банкинд олгосон санхүүжилтэй буцаан татах, үүний улмаас 267.3 сая ам.доллар буцаан дуудагдах эрсдэлтэй болох төдийгүй төлбөр гүйцэтгэх чадварт сөргөөр нөлөөлж, улмаар хувьцаа эзэмшигч бидний авах ноогдол ашиг орлогго өөрчлөгдхөх үр дагавар гарч, "ХААН банк" ХХК-ийн бүх хувьцаа эзэмшигчийн, түүний дотор "Таван Богд Трейд" ХХК-ийн хууль ёсны эрх ашиг шүүд хөндөгдж болзошгүй байгааг нотлох баримтаар нотолсон болно.

Монголбанкны Ерөнхийлөгчийн хуульд нийцэгүй, 2022 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн А-1/476 тоот шийдвэр нь ХААН банк болоод түүний хувьцаа эзэмшигч "Таван Богд Трейд" ХХК-ийн хувьд хувьцааны үнэлэмж, ноогдол ашиг буурах өндөр эрсдэл үүсгэж байгаа юм. (Хавсралт №б-д ногдол ашиг буурах тооцооллыг нотлох баримтаар хавсрагв.)

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А-1/476 дугаар бүхий албан бичиг нь Монгол Улсын банкны системийн 40 гаруй хувийг эзлэх "ХААН Банк" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Япон Улсын "Эйч Эс холдинг" ХК-ийн хувьцааны бүтцэд оруулсан өөрчлөлтийг Монгол Улсын Монголбанк хууль зөрчиж зөвшөөрснөөр ХААН Банкны удирдлагын бүтэц өөрчлөгдхөх, энэ тухай гадаадын банкууд болон олон улсын

санхүүгийн байгууллагуудад үнэн зөв мэдээлэл хүргэх, тухайн санхүүжүүлэгч байгууллагууд явагдаж буй үйл явцад дүгнэлт өгөх, өгсөн санхүүжилтээ буцаан татах, улмаар банкны төлбөр гүйцэтгэх чадварт нөлөөлж банкны зохиц харьцааны тувшин алдагдах зэрэг "ХААН Банк" ХХК-ийн хувьцаа эзэмшигч нарын эрх ашигийг шууд хөндөх эрх зүйн болоод санхүүгийн үр дагавар бий болгох болзошгүй захиргааны акт мөн юм.

Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэснээр "ХААН Банк" ХХК нь Монгол Улсын Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль, журмын хүрээнд үйл ажиллагаагаа хэлбэрэлтгүй мөрдэх, банк санхүүгийн зах зээлд тогтвортой үйл ажиллагааг явуулдаг, гадаадын банк болон олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан их хэмжээний урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрээ үр ашигтай ашиглах боломжтой болж, улмаар хувьцаа эзэмшигчдийн хувьцааны үнэ цэнэ, өгөөж баталгаатай хадгалагдах, эрх ашиг нь зөрчигдэхөөс урьдчилан сэргийлэгдэх, зөрчигдэх болзошгүй эрх ашиг нь хамгаалагдах чухал үр дагавартай юм.

Гэтэл давж заалдах шатны шүүх нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна гэж байгааг зөвшөөрөхгүй байна.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдэх болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцаян зохицуулакад оршино" гэж, З дугаар зүйлийн 3.1.3-д " "нэхэмжлэл" гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдэх болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг," гэж тус тус заасан байна.

Бид ийм хууль, дүрэм, журам зөрчсөн байдлаар цааш үргэлжлэх юм бол маш эмзэг, нарийн зохицуулалттай банк санхүүгийн салбарт хямралт үсэж, хэн дуртай нь холбогдох хууль, журмыг алгасан системийн нөлөө бүхий банкны эзнээр суух нь "Хаан банк" ХХК-ийн ойрлын ирээдүйд аюултай нөхцөл байдлыг үүсгэх болзошгүй гэж үзэж нэхэмжлэл гаргаж байхад давж заалдах шатны шүүх тэр нөхцөл байдал заавал өнөөдөр үүссэн байх эстий мэтээр дүгнэлт хийсэн нь хуулийн агуулга, зарчимд нийцэхгүй байна.

Иймд Нийслэлийн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 271/ШШ2024/0039 дугаартай шийдвэрт нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн зохих өөрчлөлтийг оруулж өгнө үү



Л.НИНЖБАТ
Л.НИНЖБАТ